

# Цар тахлын үеийн ЖДҮ-ийн салбарын бодлого: Олон улсын туршлага

---

**З. Манлайбаатар**

**Д. Оюунтөгс**

**У. Энхсайхан**

**С. Отгонбат**

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн (ЭЗСЭШХ)

## Хураангуй

“Цар тахлын үеийн эдийн засгийн бодлого: Өнгөрсөн ба ирээдүй” төслийг USAID-ын санхүүжилттэй Хөгжлийн Шийдэл ТББ-ын хэрэгжүүлж буй BEST хөтөлбөрийн захиалгаар 2022 оны 5-р сараас 9-р сарын хугацаанд хэрэгжүүлэв. Төслийн хүрээнд гурван цуврал сэдвээр судалгаа хийж, сэдэв тус бүр дээр хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Энэ төслийн хүрээнд гүйцэтгэсэн гурав дахь судалгаа нь “Цар тахлын үеийн ЖДҮ-ийн салбарын бодлого: Олон улсын туршлага” сэдэвтэй. Тус судалгаа нь цар тахлын хүндрэлтэй үед бусад улс орон, олон улсын донор байгууллагууд хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг дэмжих чиглэлээр ямар арга хэмжээ авсан, үүнээс ямар сургамж авч болохыг тодруулахыг зорьсон.

## Түлхүүр үгс:

Ковид-19, Жижиг дунд үйлдвэрлэл, Хятад, Өмнөд Солонгос, Вьетнам, Казакстан, Монгол.

Улаанбаатар, Монгол

2022



**ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА,  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ХҮРЭЭЛЭН**

**ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ**

## **ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ЖДҮ-ИЙН САЛБАРЫН БОДЛОГО: ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА**

**УЛААНБААТАР ХОТ  
2022 ОН**

## Агуулга


|                                                                                                   |    |
|---------------------------------------------------------------------------------------------------|----|
| Оршил .....                                                                                       | 3  |
| 1. Олон улсын байгууллагуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, бодлогын зөвлөмж .....                | 6  |
| Азийн Хөгжлийн Банк .....                                                                         | 6  |
| Дэлхийн Банк .....                                                                                | 9  |
| Олон Улсын Валютын Сан .....                                                                      | 11 |
| 2. Ковид-19-ийн үед бүс нутгийн орнуудын ЖДҮ-ээ дэмжих чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ ..... | 14 |
| Хятад .....                                                                                       | 15 |
| Өмнөд Солонгос .....                                                                              | 16 |
| Вьетнам .....                                                                                     | 17 |
| Казакстан .....                                                                                   | 18 |
| 3. Сургамж, дүгнэлт .....                                                                         | 20 |
| Ашигласан эх сурвалж .....                                                                        | 22 |

## Оршил

2020 оны эхнээс дэлхий дахиныг хамарсан КОВИД-19 цар тахлын үед улс орнууд хүн амынхаа амь нас, эрүүл мэндийг анхаарч, халдвар дэгдэхээс сэргийлэх, халдвар гарсан тохиолдолд дэгдэлтийг бууруулах, дархлаажуулалтыг яаралтай эхлүүлэх, халдварт өвчний эмчилгээг хүртээмжтэй, чанартай гүйцэтгэх зэрэг нийтийн эрүүл мэндийн бодлогыг чухалчилж байв. Гэвч энэ бодлого нь эрүүл мэндийн салбарт төсвөөс их хэмжээний нэмэлт зардал шаардахаас гадна, иргэдийн гадаад, дотоод аяллыг хязгаарлах, хүмүүсийн хөдөлгөөнийг хязгаарлах зэргээр иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд шууд сөрөг нөлөө үзүүлж эхэлсэн.

Цар тахлын эхэн үед улс орнууд дотоодод халдвар алдахгүйн тулд хилээ хааснаар, гадаад худалдаа, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг иргэд аж ахуйн нэгжүүд хүнд цохилтод орж байв. Мөн гадаадад гацсан иргэдийн эрх зөрчигдөж, асуудал хүндэрч байв. Дотоодод халдвар дэгдсэн үед хязгаарлалт өргөжиж, сургууль, соёл, олон нийтийн үйлчилгээний газруудыг хаах, цагийн хязгаар тогтоох, хатуу хөл хорио тогтоож байв. Энэ бүхэн нь бараг бүх аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд, ялангуяа бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдэд том цохилт болж байв. Жишээлбэл, Монгол Улсад 2020-2021 онд хоёр жилийн хугацаанд үйл ажиллагаагаа явуулсан нийт 46.0 мянган аж ахуйн нэгжээс 39.5 мянга буюу 85.9% нь Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөнд өртжээ. Энэ нөлөөг салбараар задлан дараах зурагт харуулав.

**Зураг 1. Монгол Улсад Ковид-19 цар тахал сөргөөр нөлөөлсөн аж ахуйн нэгжийн хувь, салбараар**



Эх сурвалж: (Үндэсний Статистикийн Хороо, 2022)

Дээрх зургаас харахад цар тахлын сөрөг нөлөөнд хамгийн их өртсөн салбар нь зочид буудал, нийтийн хоол, урлаг, үзвэр, боловсрол байна. Учир нь эдгээр салбарын үйл ажиллагааг төрөөс хамгийн түрүүнд хязгаарлах арга хэмжээнүүдийг авч байсан билээ.

Сүүлийн хоёр жил дараалан тасралтгүй үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжийн 20.4 мянга (44.4%) нь хатуу хөл хорионы үед үйл ажиллагаагаа хязгаарлагдмал хүрээнд явуулж байсан,

30.7% нь бүрэн зогсож, 12.9% нь зайнаас ажиллаж байсан бол дөнгөж 12% нь хэвийн ажиллаж байжээ.

Цар тахлын сөрөг нөлөөг аж ахуйн нэгжийн байршлаар авч үзвэл, хамгийн их нь нийслэлийн ААН-ийн 87.5% сөрөг нөлөөнд өртсөн бол бусад бүсэд сөрөг нөлөөнд өртсөн үзүүлэлт 81% - 84% байна.

Цар тахлын үед аж ахуйн нэгжүүдэд тулгарч буй хүндрэлийг бууруулах зорилгоор Засгийн газраас хэд хэдэн багц арга хэмжээг хэрэгжүүлсэн. Эдгээр арга хэмжээнд нийт аж ахуйн нэгжүүд хэрхэн хамрагдсаныг дараах зурагт харуулав

**Зураг 2. Ковид-19 цар тахлын үед төрөөс хэрэгжүүлсэн арга хэмжээнд ААН-ийн хамрагдалт**



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, “Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллого: Нэгдсэн үр дүн”

Хамгийн олон аж ахуйн нэгжийг хамарсан арга хэмжээ нь ААН-ийн цахилгаан, дулаан, усны төлбөрийг төрөөс даасан, ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг тодорхой хугацаанд тэглэсэн, ЖДҮ буюу 1.5 тэрбум төгрөгөөс бага орлоготой ААН-ийг ААНОАТ-аас чөлөөлсөн зэрэг шийдвэрүүд байна. Эдгээр арга хэмжээний хамрагдалт нь тухайн арга хэмжээний онцлогоос хамаарч нийслэл болон бусад бүсийн хооронд, мөн салбаруудын хооронд ялгаатай байна. Тухайлбал, ноос ноолуурын урамшуулалд хөдөө орон нутгийн ААН илүү хамрагдсан бол нийслэлээс маш цөөхөн ААН хамрагджээ. Ажлын байрыг хадгалах 3%-ийн зээлийг Худалдааны салбарын ААН-ийн 15.4% авсан бол энэ зээлийг үйлчилгээний салбарын 6.4% авсан байна.

Цар тахлын үед авч хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдээс хамгийн их мөнгөн дүнтэй хөтөлбөр нь “Эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө” юм. Энэ хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн танилцуулга болон уг хөтөлбөрийн нийт эдийн засагт болон ЖДҮ эрхлэгчдэд үзүүлсэн үр нөлөөний талаар бид энэхүү цуврал судалгааны эхний шатны тайланд дэлгэрэнгүй авч үзсэн билээ (ЭЗСЭШХ, 2022а). 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд олгосон санхүүжилт нь Ковид-19 цар тахлын эсрэг тэмцэх, бүх нийтээр дархлаажуулалтад хамрагдах бодлогын хамт ажлын байрыг олноор хамгаалах үр нөлөө үзүүлсэн. Энэ бодлого нь эдийн засаг унасан үед зээлийн өсөлтийг сэргээж, зээлийн хүүг бууруулж, ажил эрхлэлт, хөрөнгө оруулалтыг дэмжиж, бизнесийн идэвхжилээр дамжин төсвийн орлого бүрдүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн боловч зээлийн өсөлтийн нөлөөгөөр урсгал тэнцлийн

алдагдал өсөх, эрэлтийн инфляцыг нэмэгдүүлэх зэрэг сөрөг нөлөө гарчээ. Хүнс, өргөн хэрэглээний бараа үйлчилгээний үнэ төдийгүй барилгын материал, орон сууцны үнийн өсөлт хурдтай явагдсанаас үүнийг харж болно. Мөн энэ цогц төлөвлөгөө нь ажлын байрны дийлэнхийг бүрдүүлдэг, гол тусламж дэмжлэг шаардлагатай жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд төдийлөн дэмжлэг үзүүлж чадаагүй байна.

Цар тахлын үед болон түүний дараах эдийн засгаа сэргээх бодлогын хэрэгжүүлэх үед эдийн засаг, бизнест тулгарсан гол бэрхшээлүүд нь тухайн цагийн түр зуурын хүндрэл гэхээсээ эдийн засгийн илүү гүнзгий асуудлуудтай холбоотой болох нь хил гаалийн саатал, дэд бүтцийн хомсдол, төрийн байгууллагын чадавх гэх мэт олон зүйл дээр харагдах болсон. Иймээс 2021 оны 12-р сард УИХ-аас “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг баталсан. Уг бодлого нь Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэж, урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн дунд хугацааны бодлого юм. Энэ бодлогын үндэслэл буюу эдийн засгийн өсөлтийг хязгаарлагч гол хүчин зүйлс, тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаар бид энэ цуврал судалгааны хоёр дахь тайланд дэлгэрэнгүй авч үзсэн билээ (ЭЗСЭШХ, 2022b).

Цуврал судалгааны энэхүү сүүлийн хэсэгт бид цар тахлын хүндрэлтэй үед бусад улс орон, олон улсын донор байгууллагууд хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг дэмжих чиглэлээр ямар арга хэмжээ авсан, үүнээс ямар сургамж авч болохыг тодруулахыг зорилоо.

Эхний бүлэгт бид Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк, Олон Улсын Валютын Сан зэрэг донор байгууллагууд цар тахлын хүндрэлтэй үед хувийн хэвшлийг дэмжих чиглэлээр ямар арга хэмжээ авч, ямар дүгнэлт, бодлогын зөвлөмж өгч байгааг тоймлон авч үзнэ. Харин дараагийн бүлэгт Хятад, Өмнөд Солонгос, Вьетнам, Казакстан зэрэг бүс нутгийн орнуудын цар тахлын үеийн бодлого, тэдгээрийн үр дүн, сургамжийн талаар тодруулна. Эцэст нь энэхүү судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэж, бодлогын зөвлөмж дэвшүүлэх юм.

# 1. Олон улсын байгууллагуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, бодлогын зөвлөмж

## Азийн Хөгжлийн Банк

АХБ цар тахалд үзүүлэх цогц хариу үзүүлэх төслөө 2020 оны 4 сард баталсан бөгөөд энэ нь нийт 20 тэрбум ам.долларын багц юм. Хөгжиж буй гишүүн орнууддаа цар тахлын макро эдийн засаг болон эрүүл мэндийн салбарт үзүүлж буй нөлөөг бууруулахад нь туслах зорилготой. Дараах хүснэгтэд уг 20 тэрбум ам.долларын багцын задаргааг харуулж байна.

*Хүснэгт 1. Цар тахалд үзүүлэх хариу үйлдлийг санхүүжүүлэх нөөц*

| Санхүүгийн эх үүсвэр                                                  | Төрийн салбарт      | Хувийн салбарт     |
|-----------------------------------------------------------------------|---------------------|--------------------|
| (i) Нэмэлт нөөц дайчлах:                                              | \$13,754 сая        |                    |
| (a) Энгийн капиталын нөөц                                             | \$13,000 сая        |                    |
| (b) Хөнгөлөлттэй зээл                                                 | \$704 сая           |                    |
| (c) Буцалтгүй тусламж                                                 | \$50 сая            |                    |
| (ii) 2020 оны төсөл хөтөлбөрүүдийг өөрчлөх                            | \$3,721 сая         | \$1,640 сая        |
| (iii) Хэрэгжиж буй төслүүдийн нөөцийг дахин хуваарилах                | \$366 сая           | \$200 сая          |
| (iv) Хадгалсан нөөц ба цуцлагдсан төслүүдийн нөөц                     | \$281 сая           |                    |
| (v) Одоо байгаа буцалтгүй тусламжийн нөөцийг ашиглах боломжтой болгох | \$38.4 сая          |                    |
| <b>Нийт</b>                                                           | <b>\$18,160 сая</b> | <b>\$1,840 сая</b> |
| <b>Нийт багц</b>                                                      | <b>\$20,000 сая</b> |                    |

*Эх сурвалж: ADB's Comprehensive Response to the COVID-19 Pandemic*

Цар тахлын үеэр АХБ-аас хэрэгжүүлсэн гол арга хэмжээнүүдийн нэг нь CARES буюу КОВИД-19 Идэвхтэй Хариу Арга Хэмжээ ба Зардлын Дэмжлэг Хөтөлбөр (COVID-19 Active Response and Expenditure Support Program) байсан. Ерөнхийдөө улс орнуудын мөчлөг сөрсөн арга хэмжээнүүдийн санхүүжилтэд дэмжлэг үзүүлж байсан.

Түүнчлэн, АХБ-ны Хувийн Сектор Дахь Үйл Ажиллагааны Хэлтэс 2021 онд нийт төсвийнхөө 78 хувийг (3.3 тэрбум ам.доллар) цар тахлыг даван туулахад нь гишүүн орнууддаа туслахад зарцуулсан. Энэ тусламж нь голцуу ХАА-н бизнесүүд, хувийн эмнэлгүүд, ЖДҮ эрхлэгчид болон тээврийн үйлчилгээ эрхлэгчдэд чиглэсэн. Тэдний 2021 онд хэрэгжүүлсэн нийт 35 төслийн 8 нь цар тахлын шууд, шууд бус нөлөөг даван туулахад чиглэсэн.

**АХБ Монгол Улсад:**

АХБ-аас цар тахлын үеэр 525.6 сая ам.долларын өртөгтэй нийт 35 төслийг Монгол Улсад хэрэгжүүлжээ. Үүнээс 492.3 сая ам.доллар нь зээл хэлбэртэй байсны дийлэнх нь буюу 482.5 сая ам.доллар төрийн салбарт зарцуулагджээ.

ЖДҮ эрхлэгчдэд чиглэсэн нэг төсөл нь “КОВИД-19 хямралын үеэр Улаанбаатарын гэр хороолол дахь бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх төсөл” байсан. Энэ төсөл нь техникийн туслалцааны төсөл бөгөөд 3 үе шаттай хэрэгжсэн. (i) бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн чадавх, хэрэгцээ, санхүүжилтийн боломжийг судлах; (ii) чадавх бэхжүүлэх сургалтууд зохион байгуулах; (iii) тоног төхөөрөмжөөр хангах.

#### **АХБ бусад улсад:**

АХБ-аас Шри Ланк улсын ЖДҮ эрхлэгчдэд санхүүгийн шууд тусламж үзүүлэх 165 сая ам.долларын зээл баталсан. Мөн эмэгтэй удирдагчтай бизнесүүд зэрэг тусламж дутуу хүрч буй ЖДҮ-үүдэд урт хугацааны санхүүжилт олгохоор болсон.

“Номхон далайн орнуудын ЖДҮ эрхлэгчдэд цар тахлын нөлөөнөөс эргэн сэргэхэд нь тусламж үзүүлэх төсөл” нь АХБ-ны цогц хариу үйлдлийн нэг хэсэг бөгөөд 2 арга замаар тэдгээр ЖДҮ-үүдэд тусламж үзүүлнэ. (1) ЖДҮ эрхлэх орчныг сайжруулах (2) ЖДҮ-д зориулсан бизнес хөгжлийн үйлчилгээ болон санхүүжилтийг нэмэгдүүлэх.

#### **Бодлогын зөвлөмж**

АХБ-аас 2020-2021 онд “Asia SME Monitor” судалгааг 2 жил дараалан гүйцэтгэж, ЖДҮ эрхлэгчдэд үзүүлсэн цар тахлын нөлөө, ЖДҮ эрхлэгчдийн хүлээлт зэргийг судалж, цар тахлын үеэр болон дараа явуулах бодлогын зөвлөмж гаргасан (ADB, 2020; 2021).

2020 оны судалгааны үр дүнд дараах 7 бодлогын зөвлөмж гарчээ. Үүнд:

1. Зорилтот бүлгүүдэд үзүүлэх тусламж: Зорилтот бүлгүүдэд үзүүлэх тусламжийг илүү сайн дэлгэрэнгүй төлөвлөж, хязгаарлагдмал төсвийг үр ашигтай зарцуулахад анхаарах. Зорилтот бүлэгт аж үйлдвэр, бөөний болон жижиглэнгийн худалдаа, сууцаар хангах үйлчилгээ, аялал жуулчлал, тээврийн салбарын болон эмэгтэй удирдагчтай, олон улсын үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ-үүд багтана.
2. Үе шаттай аргачлал: Тодорхой бус байдал ихтэй цаг үед засгийн газрууд бодлогын арга хэмжээгээ өөрчлөх боломжтой байхын тулд үе шаттай аргачлал ашиглах хэрэгтэй. Хатуу хөл хорио ЖДҮ-үүдэд хүнд тусдаг учраас эдийн засгийн дэмжлэгийн хөтөлбөрүүд уян хатан, цаг үедээ тохирсон байх хэрэгтэй.
3. Ялгавартай бодлогын арга хэмжээ: Бодлогын арга хэмжээнүүд нь компанийн хэмжээ болон салбараар ялгаатай байх хэрэгтэй. Учир нь шокийн хэмжээ салбараар ялгаатай бөгөөд хариу үйлдэл үзүүлэх чадамж нь компани бүрд өөр байдаг. Жишээ нь бичил болон жижиг бизнесүүд цомхотгол хийх хандлагатай бол дунд хэмжээтэй компаниудад ажилчдаа халахгүйгээр ажиллах орон зай илүү байдаг.
4. Гэрээс ажиллах зохицуулалтад дэмжлэг үзүүлэх ба дижитал шилжилт: Засгийн газраас бизнесүүдийн хийж буй гэрээс ажиллах зохицуулалтыг дэмжих хэрэгтэй. Харин ЖДҮ эрхлэгчдийн хувьд гэрээс ажиллах боломж хомс ба бизнес нь ихэвчлэн биеэр ажиллахыг шаарддаг учраас дижитал шилжилтийг эрчимжүүлэх хэрэгтэй. Судалгааны үр дүнд ихэнх ЖДҮ эрхлэгчид дижитал гүйлгээний талаар мэдлэггүй бөгөөд ашигладаггүй байсан. Тиймээс, ЖДҮ эрхлэгчдийн дижитал ур чадварыг нэмэх сургалтууд зохион байгуулах хэрэгтэй.
5. Засгийн газрын дэмжлэгүүдийн талаар мэдээлэл түгээх: Засгийн газраас явуулж буй хөтөлбөрүүд, санхүүгийн дэмжлэгийн талаар мэдээлэл илүү сайн түгээх шаардлагатай. Тухайлбал, засгийн газраас хэд хэдэн санхүүгийн дэмжлэгийн хөтөлбөр хэрэгжүүлсэн ч, ихэнх ЖДҮ эрхлэгчид албан бус санхүүгийн дэмжлэгийг илүү авсан байна. Судалгаанд

хамрагдсан олон ЖДҮ засгийн газрын хөтөлбөрүүдийн талаар нэгдсэн мэдээллийн сантай болох хүсэлт илэрхийлсэн.

6. Бизнес болон ажил эрхлэлтийн аль алиныг нь хадгалах: Цар тахлын улмаас олон ЖДҮ үйл ажиллагаагаа зогсоож, цомхотгол хийснээр олон тооны ажилчид ажилгүйдлийн эрсдэлтэй нүүр тулсан. Тиймээс бизнесүүдийг дахин нээж, ажил эрхлэлтийн түвшнийг хадгалах нь маш чухал.
7. ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн нөхцөл байдлыг хянах: Засгийн газар бодлогын арга хэмжээгээ цаг алдалгүй тохируулахын тулд ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн нөхцөл байдлыг тогтмол хянах хэрэгтэй. Тодорхой бус цаг үед хамгийн оновчтой бодлого явуулах арга нь бизнесийн нөхцөл байдлыг цаг үргэлж үнэлж, ойлгох гэж оролдох явдал байдаг. Жишээ нь, ЖДҮ эрхлэгчдээс тогтмол давтамжтай судалгаа авч болно.

2021 онд явуулсан судалгаанд үндэслэж 2 үе шаттай бодлогууд явуулах зөвлөмж гаргасан. Үүнд (1) Цар тахлын үед явуулах бодлого, (2) Цар тахлын дараа явуулах бодлого. Эдгээр бодлогыг товч дурдъя.

### **Цар тахлын үед ЖДҮ эрхлэгчдийн талаар явуулах бодлого**

**Засгийн газрын дэмжлэгүүдийн талаар цаг алдалгүй мэдээлэл хүргэх:** Өмнөх судалгааны үр дүнгээс харахад засгийн газрын үйл ажиллагааны талаар мэдээлэлгүйгээс үүдэн ЖДҮ эрхлэгчдийн хүлээлт сөрөг болж байсан. Гар утасны хэрэглээ түгээмэл болсон энэ үед засгийн газрын хөтөлбөрүүдийн мэдээллийг харж болох гар утасны портал бий болгох нь нэг боломжит шийдэл юм.

**Зорилтот бүлгүүдэд хүргэх тусламжийг тус бүрийн онцлогт тохируулж хэрэгжүүлэх:** Судалгааны үр дүнд хоёр бүлэг бизнесүүд бий болсон нь харагдсан. Тухайлбал, цар тахлын нөлөө хүнд туссан ЖДҮ-үүд болон цар тахлын нөлөө эергээр туссан бизнесүүд. Энэ нь цахим үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ, эмэгтэй удирдагчтай ЖДҮ, олон улсын үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ-үүд дээр ажиглагдсан. Тиймээс тусламжийг сөрөг нөлөөнд хэр өртсөнөөс хамааруулан харилцан адилгүй хуваарилах нь зүйтэй.

**Тусламжийг үе шаттайгаар, сайн төлөвлөгдсөн төсөвтэйгөөр хэрэгжүүлэх:** Цар тахлын үед төсвийн зарцуулалт хэт их болох эрсдэл үүссэн. Засгийн газраас урт хугацаанд тогтвортой дэмжлэг үзүүлэхийн тулд хангалттай төсөвтэй байх ёстой. Тиймээс арга хэмжээг үе шаттайгаар, төсвийн сайн хяналттайгаар хэрэгжүүлэх нь зүйтэй.

**Дижитал шилжилт, бизнес дэх технологийн ашиглалтыг дэмжих:** Дижитал шилжилт нь ЖДҮ эрхлэгчдэд хэд хэдэн эерэг нөлөөтэй. Бизнесийн мэдээлэл олж авах боломжийг нэмэгдүүлэх, бизнесийн холбоо харилцааг сайжруулах, шинэ бизнесийн боломжууд бий болгож, удирдлагын зардлыг бууруулах зэрэг давуу талтай. Гэсэн хэдий ч, цар тахлын үед дижитал үйл ажиллагаа амжилттай явуулахад төвөгтэй байсан. Судалгааны үр дүнгээс харахад зайлшгүй бус бараа үйлчилгээ эрхлэгч пүүсүүд дижитал болсон үед ч бизнес орчин нь хэцүү хэвээр байсан. Зарим нь цахим худалдаа руу амжилттай шилжсэн боловч зарим стратеги муутай, гүйцэд хөгжөөгүй бизнес загварууд амжилт олоогүй. Тэгэхээр ЖДҮ эрхлэгчдэд иж бүрэн дижитал шилжилтийн тусламж хэрэгтэй. Энэ нь цахим худалдааг хөгжүүлэх заавар, цахим удирдлагын болон зардлын менежмент, дижитал санхүүжилт зэргийг агуулж болно.

### **Цар тахлын дараа ЖДҮ эрхлэгчдийн талаар явуулах бодлого**

Цар тахлын дараах бодлого нь ЖДҮ-үүдийн өсөлт, улмаар үндэсний бүтээмжийг нэмэгдүүлэх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэнэ. Өөрөөр хэлбэл, цар тахлын дараах тогтвортой, тэсвэртэй сэргэлтийг бий болгохын тулд ЖДҮ эрхлэгчдийн өсөж дэвжих чадварыг дээшлүүлнэ.

**Бизнесийн хөгжлийн үйлчилгээ үзүүлж, ажилчдад ур чадвар дээшлүүлэх сургалт орох:** Цар тахлын үед дотоодын эрэлт хумигдсан нь ЖДҮ эрхлэгчдийн хувьд нэг том асуудал. Бизнесийн өрсөлдөх чадварыг сайжруулах нь эрэлт шинээр бий болгож, цар тахлын дараах сэргэлтийн үед өсөж хөгжихөд нэн чухал. Тэр дундаа бизнес хөгжлийн зөвлөгөө болон ур чадварын сургалт нь хамгийн чухал.

**Бизнес эрхлэлтийг дэмжих инкубатор болон хурдасгуурын хөгжлийг дэмжих:** Бизнес инкубатор болон хурдасгуур нь ЖДҮ-үүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, бизнес эрхлэлтийг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй. Өсөлтөд чиглэсэн ЖДҮ-үүд болон шинэлэг гарааны бизнесүүд бий болгохын тулд илүү олон инкубатор, хурдасгуурууд байгуулах хэрэгтэй.

**Олон төрлийн санхүүжилтийн боломжуудыг хослуулах замаар бизнесүүдийг ажлын капиталар хангах:** Цар тахлын үед ажлын капиталын санхүүжилт нь бизнес оршин тогтнох эсэхийг шийдэх хэмжээний ач холбогдолтой. Цар тахлын дараа ЖДҮ-үүд санхүүжилтийн хэрэгцээгээ шийдэхэд илүү олон төрлийн санхүүжилтийн боломж шаардлагатай. Үүнд ЖДҮ-үүдэд зориулсан дижитал санхүүгийн үйлчилгээг хөгжүүлэх (мобайл санхүү, ЖДҮ хоорондын зээллэг, хувьцааны краудфандинг (equity crowdfunding) платформ гэх мэт, ЖДҮ-үүдийн хувьцааны зах зээлийг хөгжүүлэх зэрэг багтана.

**Бодлого хэрэгжүүлэхдээ хувийн секторын нөөцийг илүү ашиглах:** Засгийн газар ЖДҮ-г хөгжүүлэх зорилгоо биелүүлэхэд хувийн секторын дэмжлэгийг олж авах нь чухал. Тухайлбал, ЖДҮ-үүдийн санхүү, бизнесийн удирдлагад гаднаас мэргэжилтэн ашиглах, жишээлбэл хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодогч зэрэг зөвлөх мэргэжилтнүүдийг ЖДҮ-ийн дотоод хяналтын системийг сайжруулахад ашиглаж болно.

## **Дэлхийн Банк**

Дэлхийн Банк цар тахлын эхний 2 жил буюу 2020-2021 онд нийт 204 тэрбум ам.долларын санхүүгийн дэмжлэг улс орнуудад үзүүлсэн. 2020 оны 4 сарын 2-нд КОВИД-19 Шуурхай Арга Хэмжээ (Fast-Track Facility) буюу КОВИД-19 Стратегийн Бэлэн Байдал ба Хариу Үйлдэл Хөтөлбөрийн анхны бүлэг төслүүд батлагдсан. Эдгээр нь 1.9 тэрбум ам.долларын хэмжээтэй бөгөөд 25 улсад чиглэсэн байсан. КОВИД-19 Шуурхай Арга Хэмжээнд хамаарах төслүүд нь голцуу вакцинжуулалтыг санхүүжүүлж байсан. Шинэ төслүүд хэрэгжүүлэхээс гадна, аль хэдийн хэрэгжиж байсан төслүүдийн санхүүжилтээс дахин хуваарилалт хийх замаар цар тахлын үеийн арга хэмжээг санхүүжүүлж байсан.

2020 оны 4 сараас 9 сар хүртэл Дэлхийн Банк нийт 43 тэрбум ам.доллар зарцуулсан. 2020 оны 10 сарын 13-нд Дэлхийн Банкны Захирлуудын Зөвлөл нэмэлт 12 тэрбум ам.долларыг хөгжиж буй орнуудыг вакцинаар хангахад зориулж баталсан.

Дэлхийн Банк цар тахалд хариу үйлдэл үзүүлэх техникийн арга зүйгээ олон улсын туршлага, үнэлгээний үр дүн, хамтрагч байгууллагуудын техникийн зөвлөгөө зэрэгт суурилан боловсруулсан. Энэ арга зүй нь улс орнуудын хэрэгцээ, нөхцөл байдалд тохирсон бөгөөд 3 үе шаттай: (1) яаралтай тусламж (2) бүтцийн шинэчлэл (3) тогтвортой сэргэлт. Түүнчлэн энэ арга зүй нь 4 гол хэсгээс бүрдэнэ:

(1) Амь аврах: Вакцинжуулалт, эм, эмнэлгийн төхөөрөмжөөр хангах

(2) Ядуу, эмзэг бүлгүүдийг хамгаалах: нийгмийн халамжийн үйл ажиллагаа, мөнгөн тусламж, хоол хүнс нийлүүлэх гэх мэт.

(3) Бизнесийн тогтвортой өсөлт ба ажил эрхлэлт: бизнесүүдэд бодлогын зөвлөгөө ба санхүүгийн тусламж хүргэх

(4) Бодлого, засаглал, хөрөнгө оруулалтыг сайжруулах: засгийн газрын өрийн удирдлага, санхүүгийн шинэчлэл зэргийн талаар засгийн газруудтай хамтарч ажиллах.

Нийт хариу үйлдлийн ойролцоогоор 25 хувь нь “Амь аврах” зорилготой буюу эрүүл мэндтэй холбоотой. “Ядуу, эмзэг бүлгүүдийг хамгаалах”-д 28 хувь, “Бизнесийн тогтвортой өсөлт ба ажил эрхлэлт”-д 13 хувь, үлдсэн 36 хувь нь “Бодлого, засаглал, хөрөнгө оруулалтыг сайжруулах”-д төвлөрсөн.

Дэлхийн Банкны цар тахалд үзүүлэх хариу үйлдэл нь бага болон дундаас доогуур орлоготой орнууд, Эмзэг, Зөрчилдөөн, Хүчирхийлэл (ЭЗХ) бүлгийн орнууд болон арлын жижиг орнуудад санхүүгийн урсгал, техникийн дэмжлэгийг нэмэгдүүлэхэд төвлөрсөн. 9 сарын эцэс гэхэд батлагдсан 43 тэрбум ам.доллараас 25 тэрбум ам.доллар нь Олон Улсын Хөгжлийн Холбоо (ОУХХ)-ны гишүүн орнуудад зориулагдсан. Үүний 38 хувь нь хямралыг даван туулахад тусгайлан зориулагдсан. Түүнчлэн ОУСБХБ-ны санхүүжилт 18 тэрбум ам.долларын 71 хувь нь хямралыг даван туулахад тусгайлан зориулагдсан байв. ЭЗХ бүлгийн орнуудын санхүүжилт 7.6 тэрбум ам.доллар байсан бол арлын жижиг орнуудын санхүүжилт 0.6 тэрбум ам.доллар байсан (эдгээрийн 33 хувь нь хямралыг даван туулахад тусгайлан зориулагдсан).

Дэлхийн банк хариу үйлдэлдээ хөрөнгө оруулалтын төслүүд, хөгжлийн бодлогын үйл ажиллагаа (ХБҮА) зэрэг бүх арга хэрэгслээ ашиглаж байна. Эдгээрийг хэрхэн хослуулж ашиглахыг улс орнуудын хэрэгцээ, цар тахлын шинж чанар, санхүүжилтийн эх үүсвэрүүд зэргээс хамааруулан шийдсэн. ХБҮА-ны дэмжлэгтэйгээр улс орнууд бодлогын болон засаглалын шинэчлэл хэрэгжүүлж байна. ОУХХ-ны гишүүн орнууд ХБҮА-г цар тахлын хариу үйлдэлд илүү ашигласан.

Дэлхийн банкны цар тахалд үзүүлэх хариу үйлдэл нь хамгийн ядуу орнуудын хэрэгцээг нэн тэргүүнд тавьсаар ирсэн. 2020 оны 4 сараас 6 сарын хооронд Дэлхийн банкны баталсан хариу үйлдлийн хэмжээ бусад бүх олон талт хөгжлийн банкнуудын хариу үйлдлийн нийлбэртэй тэнцэж байсан. Тус хугацаанд Дэлхийн банк болон бусад олон талт хөгжлийн банкнууд нийтдээ 45 тэрбум ам.долларын хариу үйлдэл баталсан байна. Мөн ОУХХ болон ОУСБХБ нийтдээ 32 тэрбум ам.долларын зээлийг засгийн газруудад олгосон бол бусад хөгжлийн банкнууд нийтдээ 31 тэрбум ам.долларын зээл олгожээ.

Цар тахлын хариу үйлдлийн улмаас зарцуулалт нэмэгдсэн. 2021 оны эхний улиралд зарцуулалт 11.8 тэрбум ам.долларт хүрч, 2020 оны эхний улирлын 6.4 тэрбумтай харьцуулахад бараг 2 дахин их болсон. Түүнчлэн зарцуулалт хэвийн үеийнхтэй харьцуулахад хурдан байсан. Жишээ нь, 1.2 тэрбум ам.доллар эхний хэдхэн сарын дотор зарцуулагдсан. ХБҮА-ны зарцуулалтын нийт зардалд эзлэх хувь өссөнөөр 2021 оны эхний улиралд 6.3 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд 2020 оны эхний улирлын 1.8 тэрбумтай харьцуулахад өндөр байна.

Дэлхийн банкны хямралд үзүүлж буй хариу үйлдлийн нөлөөгөөр ОУХХ-ны гишүүн орнуудын цэвэр мөнгөн урсгал өсөж, тэдгээр орнууд бүгд эерэг мөнгөн урсгалтай болсон байна. Дэлхийн банк бусад хөгжлийн банкнуудтай хамтран Зээлийн Төлөлтийг Хойшлуулах Санаачилга (DSSI)-д хувь нэмэр оруулах боломжуудыг судалсан. Учир нь Дэлхийн банк улс орнуудыг хямралын үеэр их хэмжээний эерэг мөнгөн урсгалтай байлгаж, өрийн эрсдэлээс хол байлгах үүрэгтэй. Тухайлбал, ОУХХ нь буцалтгүй тусламж болон хүүгүй, урт хугацаатай зээл олгох чадамжтай.

ОУХХ болон ОУСБХБ-аас гадна Дэлхийн банкны бусад гишүүн байгууллагуудын зүгээс хариу үйлдэлд хувь нэмэр оруулсан. Тухайлбал, Олон Улсын Санхүүгийн Корпорац (ОУСК) бизнес,

ажлын байруудыг хадгалах зорилгоор 8 тэрбум ам.долларын санхүүжилт олгосон. Энэ санхүүжилтийн ихэнх нь ЖДҮ эрхлэгчид болон эмэгтэй бизнес эрхлэгчдэд хүрсэн.

Олон Талт Хөрөнгө Оруулалтын Батлан Даалтын Агентлаг (MIGA)-аас хувийн секторын хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчдэд туслах зорилгоор 6.5 тэрбум ам.долларын санхүүжилт олгосон. Энэ санхүүжилт нь эмнэлгийн тоног төхөөрөмжийн яаралтай худалдан авалт, ЖДҮ эрхлэгчдийн ажлын капитал, засгийн газруудын богино хугацааны санхүүгийн хэрэгцээ зэргийг мөн санхүүжүүлсэн.

#### **Дэлхийн Банк Монгол Улсад:**

Европын Холбооны санхүүжилттэй Монгол Улсад Засаглалыг Бэхжүүлэх Төслөөс 750,000 ам.долларыг (€680,000) цар тахлын нөлөөг бууруулахад чиглэсэн, илүү төвлөрсөн, түр зуурын арга хэмжээнд зориулан дахин хуваарилсан. Тэдгээр арга хэмжээнд цар тахлын эдийн засагт үзүүлж болох нөлөөг үнэлэх, санхүүгийн нөөцийг төлөвлөх, хянах, хуваарилалт болон зарцуулалтад илүү сайн хяналт тавих зэрэг багтсан.

Ажил Эрхлэлтийг Дэмжих Төслийн нөөцийг мөн Засгийн газрын цар тахалд үзүүлэх хариу арга хэмжээнд зарцуулсан. Үүнээс 15 сая ам.долларыг хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил бизнес эрхлэгчид болон албан бус ажил эрхлэгчид зэрэг нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагч 120,000 иргэний даатгалын шимтгэлийг 5 сарын турш хөнгөлөхөд зориулсан. Тус төслийн хүрээнд 2.6 сая ам.долларын санхүүжилттэй бичил зээлийн хөтөлбөрөөр зээлдэгчдийг зээлийн хүүгээс түр зуур чөлөөлсөн.

Монгол Улсад Яаралтай Тусламжийн Төсөл болон Ажил Эрхлэлтийг Дэмжих Төслийн 20 сая ам.долларын нөөцөөр шаардлага хангасан ажилчид болон ажил эрхлэгчдэд түр зуурын хөнгөлөлт үзүүлж, ажил хайгч болон бичил бизнес эрхлэгчдэд хөдөлмөрийн зах зээлд оролцох боломж олгоход зарцуулсан. Үүнээс 10 сая ам.долларыг Нийгмийн Даатгалын Сан руу шилжүүлж албан журмаар даатгуулагч шаардлага хангасан ажил олгогч болон ажилчдын шимтгэлийн хөнгөлөлтийг санхүүжүүлсэн.

Экспортыг Дэмжих Төслөөс 1.5 сая ам.долларыг албан журмын даатгуулагчдад ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэхэд зарцуулсан. Энэ нь цар тахлын улмаас борлуулалт нь 50 хувиас дээш унасан ч ажилчдаа халаагүй уул уурхайн бус ЖДҮ эрхлэгчдэд шууд бус дэмжлэг үзүүлэх, улмаар үйл ажиллагаагаа хадгалахад нь туслах зорилготой бөгөөд дор хаяж 300 уул уурхайн бус ЖДҮ-ийн 7,000 даатгуулагчид үр нөлөөгөө өгөх хүлээлттэй.

## **Олон Улсын Валютын Сан**

Олон Улсын Валютын Сан улс орнуудад бодлогын зөвлөгөө өгөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, чадавх бэхжүүлэх, ядуу орнуудын өрийг хөнгөлөх зэргээр цар тахлын дараах сэргэлтээ хийхэд нь тусалсаар байна. Ингэхдээ дараах чиглэлийн үйл ажиллагааг голлон явуулж байна.

1. Яаралтай санхүүжүүлэлт – ОУВС яаралтай тусламжийн 2 гол хэрэгсэл болох Хурдан Зээлийн Хөтөлбөр (RCF) болон Яаралтай Санхүүжилтийн Хэрэгсэл (RFI)-ийн үйл ажиллагааг 2 дахин тэлсэн. Одоогоор нийт 90 улсад 122.6 тэрбум Зээлжих Тусгай Эрх (ЗТЭ) буюу 170.6 тэрбум ам.долларын санхүүгийн тусламж үзүүлээд байна.

#### ***Хүснэгт 2. ОУВС-ын санхүүгийн дэмжлэг, бүс нутгаар***

|                            | Зээлжих Тусгай<br>Эрх | Ам.доллар     |
|----------------------------|-----------------------|---------------|
| Ази, Номхон Далай          | 1,890.0 сая           | 2,622.8 сая   |
| Европ                      | 4,819.1 сая           | 6,676.9 сая   |
| Ойрхи Дорнод ба<br>Төв Ази | 12,312.4 сая          | 17,021.8 сая  |
| Сахараас урагших<br>Африк  | 18,551.9 сая          | 25,934.2 сая  |
| Хойд ба Өмнөд<br>Америк    | 85,069.1 сая          | 118,315.1 сая |

Эх сурвалж: (IMF, 2021) COVID-19 Financial Assistance and Debt Service Relief Tracker

- Өрийг хөнгөвчлөх буцалтгүй тусламж – ОУВС Сүйрлийг саатуулах, тусламж үзүүлэх итгэлцэл (ССТҮИ)-ээр дамжуулан хамгийн ядуу ба эмзэг 29 гишүүн орондоо 2020 оны 4 сараас 2021 оны 10 сар хүртэл хугацаанд зээлийн хөнгөлөлт үзүүлсэн. Түүнчлэн хөнгөлөлтийн хугацааг 2022 оны 4 сар хүртэл буюу 2 жилээр сунгахын тулд ОУВС донор байгууллагуудтай хамтарч, ССТҮИ-ийн нөөцийг нэмэгдүүлэхээр ажилласан. Одоогоор нийт 31 оронд 689.58 сая ЗТЭ буюу 965.29 сая ам.долларын зээлийн хөнгөлөлт үзүүлээд байна.
- Хоёр талт өрийн хөнгөлөлт – 2020 оны 3 сард ОУВС болон Дэлхийн Банкны удирдлагууд 2 талт зээлдүүлэгчдэд хамгийн ядуу орнуудын зээлийн төлбөрийг хойшлуулах санал тавьсан. G20-ын орнууд уг саналыг зөвшөөрч, хамгийн ядуу орнуудын 2 талт зээлийн эргэн төлөлтийг 2020 оны эцэс хүртэл, улмаар 2021 оны эцэс хүртэл хойшлуулсан. Энэ санаачилгыг Зээлийн Төлбөрийг Хойшлуулах Санаачилга (DSSI) гэх бөгөөд 48 бага болон дунджаас доогуур орлоготой орнуудын G20-ын 2 талт зээлдүүлэгчдээс авсан зээлийн төлбөрийг хойшлуулсан. 2020 оны 5 сараас 2021 оны эцэс хүртэл нийт 12.9 тэрбум ам.долларын зээлийн төлөлтийг хойшлуулсан байна.
- 650 тэрбум ам.долларын шинэ ЗТЭ-ийн хуваарилалт – 2021 оны 4 сард Олон Улсын Мөнгө Санхүүгийн Зөвлөл (IMFC)-өөс 650 тэрбум ам.долларын ЗТЭ шинээр хуваарилахыг ОУВС-д санал болгосон. Зорилго нь дэлхий дахины урт хугацааны санхүүгийн хэрэгцээг хангах байсан.
- Хөрвөх чадварыг сайжруулах – ОУВС Богино Хугацааны Хөрвөх Чадварын Шугам (SLL)-ыг олон улсын санхүүгийн тогтвортой байдлыг хүчирхэгжүүлэх зорилгоор байгуулсан. Энэ шугам нь богино хугацааны төлбөрийн тэнцлийн дэмжлэг хэрэг болсон, маш сайн бодлого, үзүүлэлттэй гишүүн орнуудад нээлттэй.
- Одоо байгаа зээллэгт өөрчлөлт оруулах – ОУВС одоо байгаа зээллэгийн хөтөлбөрүүддээ өргөтгөл хийж, цар тахалтай холбоотой урган гарч буй хэрэгцээг хангаж байна.
- Бодлогын зөвлөгөө – ОУВС нь цар тахлын нөлөө, эдийн засгийн нөхцөл байдлыг олон улс, бүс нутаг, улс орны түвшинд хянаж, хямралыг даван туулах, эмзэг бүлгүүдийг хамгаалах, эдийн засгийн сэргэлтийн эхлэлийг тавих зэрэгт шаардлагатай бодлогуудыг зөвлөмж болгодог.
- Чадавх бэхжүүлэх – ОУВС 160 гаруй орнуудыг бэлэн мөнгөний менежмент, санхүүгийн хяналт, цахим аюулгүй байдал, эдийн засгийн засаглал зэрэг тулгамдсан асуудлуудаар бодлогын зөвлөмж, чадавх бэхжүүлэлтээр хангаж байна. Ялангуяа татвар, төсөвтэй холбоотой байгууллагуудтай хамтран ажилладаг. ОУВС-ийн мэргэжилтнүүд улс

орнуудын өрийн удирдлагын стратегийг шинэчилж, сайжруулахаар хамтран ажиллаж байна. Түүнчлэн, ОУВС-ийн цахим хичээлүүд төрийн албан хаагчид болон олон нийтэд илүү урт хугацаагаар хүрэх боломжтой болсон.

## **2. Ковид-19-ийн үед бүс нутгийн орнуудын ЖДҮ-ээ дэмжих чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ**

Дэлхий дахиныг хамарсан Ковид-19 цар тахалтай тэмцэх, халдварын тархалтыг бууруулахын тулд олон улс хилийн хязгаарлалт, дотоодын хөл хорио тогтоох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн. Цар тахлын үеийн хязгаарлалтын арга хэмжээнүүдийн улмаас олон улсын эдийн засаг зогсонги байдалд шилжиж, эдийн засгийн хямрал үүссэн. Тэр дундаа, бичил болон ЖДҮ-ийн үйл ажиллагаа доголдож, олон ажлын байр устсан нь эдийн засгуудын хувьд шинэ сорилт болж байна. Энэхүү бүлэгт бид олон улсад ЖДҮ-ийг дэмжих чиглэлд ямар бодлогын арга хэмжээнүүдийг хэрхэн хэрэгжүүлснийг авч үзнэ.

Ковид-19-ийн үед бичил, жижиг дунд бизнесийн үйл ажиллагааг дэмжих чиглэлд улс орнуудын авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээнүүдийг ерөнхийд нь дараах дөрвөн бүлэгт хуваан авч үзэж болох юм (United Nations ECLAC, 2021).

- ЖДҮ-ийн хөрвөх чадварыг дэмжих арга хэмжээ
  - Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт
  - Ажил олгогчийн зүгээс төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулах, чөлөөлөх
  - Банкны зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах, хүүгээс чөлөөлөх
  - Дулаан, цахилгааны төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх
  - Хугацаа хэтэрснээс үүдсэн торгууль, шимтгэлээс чөлөөлөх
  - Түрээсийн чөлөөлөлт
- Ажил эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг хадгалахад чиглэсэн арга хэмжээнүүд
  - Ажлын цагийг богиносгох
  - Төрөөс нийгмийн даатгал бусад албан шимтгэлийг төлөх
  - Ажил олгогчид болон төрөөс хэрэгжүүлсэн хязгаарлалтын арга хэмжээний улмаас ажилгүй болсон иргэдэд шууд татаас олгох
- Үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүд
  - Төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх
  - Төрөөс хэрэгжүүлж буй дэмжлэгийн арга хэмжээнд хамрагдалтын түвшнийг нэмэгдүүлэх зорилгоор бизнесүүдийн албан ёсны бүртгэлийг эрчимжүүлэх
  - Эрүүл мэндийн хямралыг давахад шаардлагатай тоног төхөөрөмж, түүхий эд, материал болон шийдлүүдийг дэмжих урамшууллын арга хэмжээнүүд
  - Дижитал платформын хэрэглээг техникийн тусламжийн үйлчилгээ болон үйлдвэрлэл нэвтрүүлэлтийг дэмжих
  - Бичил, ЖДҮ-ийн борлуулалтын сувгийг дэмжих, онлайн сувгийг идэвхжүүлэх
- Санхүүгийн дэмжлэг
  - Шууд санхүүжилтийн арга хэмжээнүүд: Хөнгөлөлттэй зээл олгох г.м.
  - Санхүүгийн хүртээмжийг сайжруулах бодлогууд
  - Батлан даалтын санг өргөжүүлэх

Олон улсын туршлагаас харахад Ковид—19-ийн үед ЖДҮ-ийг дэмжих бодлогуудын хүртээмжийг сайжруулахад түлхүү анхаарсан байна. Хүртээмжийг сайжруулах чиглэлд нэгдүгээрт, зорилтот мэдээллийг олон нийтэд нээлттэй, хүртээмжтэйгээр мэдээлэх, хоёрдугаарт, албан бус бичил болон жижиг, дунд үйлдвэрлэгчдийн албан ёсны бүртгэлд хамруулах гэх хоёр арга хэмжээг түлхүү хэрэгжүүлэв. Түүнчлэн, төв болон орон нутгийн Засгийн газруудын харилцан уялдаатай байдал, бүх шатны төрийн байгууллагын шуурхай ажиллагаа, хариуцлагын нягт нямбай систем нь Засгийн газрын бодлогын хэрэгжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх нөлөөтэй

байна. Засгийн газрын институтийн үр ашигтай бүтэц, үйл ажиллагааны үр дүнтэй байдал нь бодлогын үр нөлөөг сайжруулж байгааг БНХАУ болон Вьетнам улсын жишээнээс харж болж байна. Түүнчлэн, төрийн үйлчилгээний шуурхай, хүнд сурталгүй системийн үр ашиг Солонгос улсын жишээнээс харагдаж байна. Харин Казахстан улс нь маш олон төрлийн арга хэмжээ хэрэгжүүлсэн ч засаглалын чанаргүй байдал, мэдээллийн ил тод байдал муу, институтийн чанар муу зэрэг хүчин зүйлсээс хэрэгжүүлсэн бодлогуудын хүртээмж муу, үр ашиг бага байв.

Дараах хэсэгт эдгээр улсын хэрэгжүүлсэн бодлого болон үр дүнг тоймлов.

## Хятад

Ковид-19 цар тахлын үед Хятадын Засгийн газар вирусийн тархалтыг хумих хатуу хөл хорионы стратегийг баримталснаар эдийн засаг, тэр дундаа ЖДҮ-ийн үйл ажиллагаа ихээр доголдсон. Хөл хорионы дэглэм цуцлагдсаны дараа тус улсын Засгийн газар ЖДҮ-ийн үйл ажиллагаа сэргээх, дэмжих томоохон бодлогын хөтөлбөрүүдийг дорвитой авч хэрэгжүүлсэн нь амжилттай болжээ. Тус улсын Аж үйлдвэр, мэдээллийн технологийн яамны мэдээлсний дагуу 5-р сарын дунд үе гэхэд нийт ЖДҮ-ийн 90 гаруй хувь нь үйл ажиллагаагаа сэргээсэн ажээ (EBRD, 2021).

БНХАУ-ын Засгийн газрын хувьд нэн тэргүүнд ЖДҮ-ийн бодлогын мэдээллийн хүртээмж, засгийн газрын бүх үе шат дахь нэгжийн үүрэг, хариуцлагын тогтолцоог тодорхой тодорхойлсон нь бодлогын үр дүн сайн байхад нөлөөлөв. Тухайлбал, БНХАУ-ын Засгийн газар өөрийн албан ёсны нэгдсэн вэбсайтад тусгай мэдээллийн сан үүсгэж, зөвхөн ЖДҮ-ийг дэмжих чиглэлд хэрэгжүүлж буй бодлогын бүх арга хэмжээний жагсаалт, дэлгэрэнгүй мэдээллийг байршуулжээ. Түүнчлэн, БНХАУ-ын Засгийн газар Ковид-19-ийн үед ЖДҮ-ийг дэмжих чиглэлд бодлого хэрэгжүүлэхдээ орон нутгийн бизнесүүдэд нэн шаардлагатай арга хэмжээг тандах, тогтоох багуудыг бүс нутгуудад томилж, бизнесийн холбоодын үйл ажиллагааг өргөтгөх тал дээр онцгой анхаарчээ. Жишээлбэл, Шэньжень хотын захиргаа бичил болон ЖДҮ-үүд үйл ажиллагаагаа дахин эхлүүлэхтэй холбоотой хүсэлт гаргах үед орон нутгийн удирдах байгууллага 24 цагийн дотор шуурхай хариу өгөх түргэвчилсэн системийг нэвтрүүлэн ажиллаж байв. Мөн тус улс зорилтот бодлогуудын хэрэгжилтийг харьяа орон нутгийн удирдлагуудад хариуцан ажиллах механизмыг нэвтрүүлэв. Улмаар орон нутгийн удирдлагуудын бодлогын хэрэгжилтийн үнэлгээг Ковид-19-ийн тархалтын бууралт болон тухайн орон нутгийн эдийн засгийн идэвхжилийн сэргэлтээр үнэлж байв.

БНХАУ-ын хувьд ЖДҮ-ийн үйл ажиллагааг дэмжих дараах бодлогуудыг хэрэгжүүлжээ (EBRD, 2021). Үүнд:

- **ЖДҮ-ийн хөрвөх чадварыг дэмжих бодлого:** Төв банк заавал байх нөөцийн нормоо 1 нэгж хувиар бууруулж, 400 тэрбум юань буюу 57 сая ам.долларын урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэрийг чөлөөлөв. Улмаар ЖДҮ-д хөнгөлөлттэй хүү бүхий тусгай зээлийн квот тогтоо өгөв. Түүнчлэн, зээлийн эргэн төлөлтийг хойшлуулж, хойшлуулсан зээлийн мэдээллийг зээлийн мэдээллийн санд нөлөөлөхгүй байхаар зохицуулжээ.
- **ЖДҮ-ийн үйл ажиллагааны зардлыг хөнгөвчлөх бодлого:** Бээжин болон Шанхай хотуудад төрийн өмчийн байгууламжид үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ-үүдийг түрээсийн зардлаас чөлөөлөв. НӨАТ-ыг бууруулж, зарим бүс нутаг дахь бичил бизнес эрхлэгчдийн хувьд тэглэж, орон нутгийн татвар, хураамжийг бууруулах зөвшөөрлийг олгов. Мөн цахилгааны төлбөрийг 5 хувь бууруулах, дулааны төлбөрийг хойшлуулах боломж олгох, хурдны замын төлбөрийг түр хугацаанд тэглэх, мэргэжлийн сургалтын татаасыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлжээ.
- **Хэрэглэгчдийн эрэлтийг дэмжих арга хэмжээ:** 4-р сарын дунд гэхэд БНХАУ-ын 80 орчим хотод 1.4 сая ам.долларын бараа худалдан авах эрхийн бичгийг хэрэглэгчдэд

тараасан аж. ЖДҮ-үүдийн онлайн худалдаа, маркетингийг платформ ашиглалтыг дэмжих зорилгоор цахим платформууд дахь шаардлагыг бууруулах чиглэлийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэв. Түүнчлэн, Засгийн газар худалдан авалт хийхдээ ЖДҮ-ийг илүүтэй сонгох стратеги баримтлав.

- **Хууль эрхзүйн орчны уян хатан байдлыг бүрдүүлэх:** Ресторануудын ширээ хоорондын зайн шаардлагыг хангахын тулд ресторануудыг гадаа талбайд ширээ байршуулахыг зөвшөөрөв. Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахын тулд арилжааны банкны зээлийн мэргэжилтнүүдийн чанаргүй зээлтэй холбоотой хүлээх хариуцлагын арга хэмжээг цуцлав.

БНХАУ-ын хувьд институтын хамгийн бага нэгжээс эхлээд засгийн газрын бүх шатны нэгжүүдийн оролцоо, хяналтын тогтолцоог нэн тэргүүнд тавьж, нэг талаас цар тахлын тархалтын хумих, нөгөө талаас эдийн засгийн идэвхжилийг сэргээх бодлогуудыг тэнцвэртэй хэрэгжүүлжээ. Түүнчлэн, орон нутаг бүрийн онцлогт тохирсон бодлогыг томьёолон хэрэгжүүлснийг онцлох хэрэгтэй.

## Өмнөд Солонгос

Солонгос улсын хувьд ЖДҮ-чдийн үйл ажиллагааг дэмжихдээ нөхцөлт урамшууллын арга хэрэгслүүдийг ашиглахаас гадна төрийн үйл ажиллагааны зардлыг хэмнэх, түргэвчлэх арга хэмжээнүүдийг түлхүү хэрэгжүүлжээ. Тухайлбал, гаалийн нэвтрүүлэлтийн болон хяналт шалгалтын үе шат, хугацаа, зардлыг бууруулах түргэвчилсэн арга хэмжээнүүд нь хамгийн үр дүнтэй байв. Тус улсын Засгийн газраас Ковид-19-ийн үед ЖДҮ-ийг дэмжих чиглэлд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлжээ (European Bank for Reconstruction and Development, 2020).

- **Үйл ажиллагааны зардлыг бууруулах, чөлөөлөх арга хэмжээ:** Нисэх онгоцны буудлын худалдааны хэсэгт байрлах ЖДҮ-чдийн түрээсийн зардлыг 6 сарын турш 25%-аар бууруулсан бол Солонгосын худалдаа, даатгалын корпорац тус улсын нийт экспортлогч ЖДҮ-чдийн даатгалын хураамжийг 50%-аар бууруулжээ. Вирусийн тохиолдол бүртгэгдсэнээс үйл ажиллагаа зогсоосон бизнесүүдэд татварын хөнгөлөлт эдлүүлжээ. Тухайлбал, зарим төрлийн татварын ногдуулалт болон төлөлтийн хугацааг 6 сараар хойшлуулж, хойшлуулсан хугацааг дахин зургаан сараар хойшлуулах боломжит нөхцөлийг бүрдүүлэв. Аж ахуйн нэгжийн татвар болон НӨАТ-ын төлөлтийг мөн 9 сараар хойшлуулжээ. Түүнчлэн, зээлийн эргэн төлөлтийн хугацааг хамгийн багадаа 6 сараар хойшлуулах, 6 сар хүүг тэглэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлжээ.
- **Хөрвөх чадварыг нэмэгдүүлэх санхүүгийн дэмжлэгийн багцууд:** Солонгосын засгийн газар төв банк, төрийн өмчийн хөгжлийн банкнууд болон санхүүгийн салбарын бүхий л нэгжүүдтэй хамтран цар тахлаас үүдэн санхүүгийн хүндрэлтэй нүүр тулсан ЖДҮ-ийг дэмжих арга хэмжээнүүдийг хэрэгжүүлжээ. 41.8 их наяд вон буюу ДНБ-ийнхээ 2.1%-тай тэнцэх хэмжээний санг ЖДҮ-т зээл олгох, санхүүгийн салбарыг тогтворжуулах чиглэлд зарцуулахаар төлөвлөжээ. Солонгосын зээлийн баталгааны сан, Солонгосын Технологийн санхүүжилтийн корпорац бүрэн болон тусгайлсан баталгаатай, бага хүүтэй зээлийг ЖДҮ-үүдэд олгов. Цар тахлын нөлөөгөөр шууд болон шууд бусаар хохирсон, жилийн борлуулалтын орлого нь 100 сая воноос бага аж ахуйн нэгжүүдэд бүрэн баталгаатай, шуурхай зээл олгожээ.
- **Эрэлтийг дэмжих татварын урамшууллын арга хэмжээ:** Хувийн сектор дахь урьдчилж төлөөд, урьдчилж худалдан авах худалдан авалтыг дэмжих бодлогыг хэрэгжүүлж байгаа аж. Засгийн газраас 2020 оны 4-р сараас 7-р сарын 4 сарын хугацаанд кредит карт болон дебит карт хэрэглэгчдэд 80%-ийн орлогын татварын хөнгөлөлт эдлүүлэв.

- **Ажлын байрыг хамгаалах төсвийн дэмжлэгийн хөтөлбөрүүд:** Тус улсын Засгийн газраас ажлын байрыг хадгалах чиглэлд дэмжлэг үзүүлэхээс гадна ажил олгогч болон ажилчдад тулгарсан хүндрэлийг шийдвэрлэх арга хэмжээнүүдийг нэвтрүүлжээ. Бизнесүүдийн ур чадвартай ажилчдыг хадгалах замаар өрсөлдөх чадварыг хадгалж үлдэхэд илүү чиглэсэн бөгөөд ингэснээр хямралын дараа бизнесүүдийн үйл ажиллагаа хурдан сэргэх боломжтой гэж үзжээ. Ажлын байрны тогтвортой байдлыг хадгалах сан хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлж, ажилчдын цалинд татаас олгох мөн Гамшгийн үеийн ажил эрхлэлтийн тогтвортой байдлыг хадгалах татаасны системийг нэвтрүүлж, ЖДҮ-ээс цалингүй чөлөөлөгдсөн ажилчдад 3 сарын турш сарын 500,000 воны татаас олгов.
- **Удирдлагын үйл ажиллагааг хялбарчлах, түргэвчлэх арга хэмжээ:** Төрийн худалдан авалтын гэрээ байгуулалтын үйл явцыг түргэсгэх арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Тухайлбал, Засгийн газраас дотоодын аж үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг хангахын тулд импортын түхий эд болон орцын материалуудыг гаалийн нэвтрүүлэлтийг шуурхайлуулж, гаалийн нэвтрүүлэлтийн бүсийн үйл ажиллагааг 24 цагаар ажиллуулав. Төрийн шууд худалдан авалтын дээд хэмжээг нэмэгдүүлж, сонгон шалгаруулалтын процессын тоог цөөлөв. Төрийн худалдан авалтын хяналт, шалгаруулалтын хугацааг 12 долоо хоногоос 8 долоо хого болгож богиносгожээ. Мөн тендерийн сонгон шалгаруулалтын суурь хураамжийг 50%-аар бууруулж, ЖДҮ-чдийн оролцоог дэмжив. Солонгосын гаалийн үйлчилгээний газраас экспортлогч, импортлогч болон ажлын байраа хадгалж үлдсэн ЖДҮ-чдэд гаалийн хяналтын хураамжийн хугацааг хойшлуулах арга хэмжээг хэрэгжүүлэв. Экспорт, импортын банкнаас шилжүүлгийн түүх болон зээлжих зэрэглэл тогтоогдоогүй ЖДҮ-үүдэд зориулан нийт 200 тэрбум воны сантай шуурхай зээлийн хөтөлбөрүүдийг шинээр санал болгожээ. Жирийн үед ЖДҮ-чдэд зээл олгохдоо тодорхой хугацаанд чанарын үнэлгээ хийдэг байсан бол хямралын үед зөвхөн санхүүгийн тайлангийн хяналт л хийж байгаа ажээ.

## Вьетнам

Вьетнам улс нь Ковид-19 цар тахлын хамгийн анхны тохиолдол бүртгэгдсэн ч хамгийн богино хугацаанд цар тахлын тархалтыг хумьж, эдийн засгийн үйл ажиллагааг дахин нээж чадсан сайн жишээгээр нэрлэгдэж байна. Тус улсын цар тахлын хариу арга хэмжээнүүдийн үр дүнд хүрэхэд засаглалын үр ашиг, нээлттэй байдал, болон засгийн газрын бүх шатны байгууллагуудын бодлогын уялдаатай байдал нөлөөлсөн гэж үзэв.

Вьетнам улсын хувьд Ковид-19 вирусийн анхны тохиолдол 2020 оны 1-р сарын сүүлээр буюу цар тахлын нэршил өгөгдөөгүй байхад илэрч, сургуулиудыг хаах, бүх нийтийн хөл хорио болон хил хаах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв. Бүх нийтийг хамарсан хөл хориог хэрэгжүүлсэн БНХАУ-ын удаах хоёр дахь улсаар нэрлэгдэж байв. 2020 оны 3-р сард Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас Ковид-19 цар тахлыг албан ёсоор зарлах үед Вьетнамын Засгийн газар хүн хоорондын зай барих дүрэм, маск зүүх зэрэг дүрмүүдийг хэрэгжүүлж, зөрчсөн тохиолдолд торгууль ногдуулах арга хэмжээг хэрэгжүүлжээ. Цаашилбал, ерөнхий сайд эрүүл мэндийн төлөө “эдийн засгийн золиос” байх ёстой хэмээн зарлаж байв.

Ийнхүү Вьетнамын Засгийн газар Ковид-19-ийн халдварын тархалтыг амжилттай хумьж чадсан ч эдийн засаг, тэр дундаа бичил, жижиг дунд үйлдвэрлэлийн салбар маш том уналтад оров. Тухайлбал, 2020 оны байдлаар 2019 онд үйл ажиллагаа явуулж байсан орон нутгийн аж ахуйн нэгжүүдийн 63% нь хэрэглэгч олох, 35% нь зээл авах, 34% нь ажилтан олох, 28% нь бизнесийн хамтрагч олоход хүндрэлтэй байсан бол 27% нь зах зээлийн уналттай байна гэж тайлагнажээ (Nguyen, 2022). Улмаар тус улсын Засгийн газраас бусад улсын нэгэн адил дотоодын аж ахуйн

нэгжээс нийгмийн даатгал болон амь даатгалын шимтгэлийг төрөөс даах, цалингийн зардалд зориулсан хөнгөлөлттэй, шуурхай зээл олгох, ажлын байрнаас чөлөөлөгдсөн ажилчдад олгох нийгмийн халамжийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлжээ. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхдээ “Мэдээллийн хүртээмжийн хууль”-ийн дагуу иргэд, аж ахуйн нэгжүүдэд Засгийн газрын Ковид-19-тэй холбоотой бүх шилжүүлэг, зарлагыг нэг бүрчлэн нарийвчлалтайгаар мэдээлж байв (Nguyen, 2022).

Түүнчлэн орон нутгийн удирдлагууд аялал жуулчлал, хөдөө аж ахуй болон далайн хүнс зэрэг салбарын жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжихийн тулд бусад орон нутгийн удирдлагуудтай дотоодын ЖДҮ-чдийн хамтын ажиллагааг дэмжих бодлогыг томьёолон хэрэгжүүлэв. Түүнчлэн, бизнесийн үйл ажиллагааг тухайн үеийн хамгийн эрэлттэй чиглэл рүү хөрвүүлэх стратегиуд хэрэгжүүлэв. Эдгээр арга хэмжээнүүд нь гадаадын эрэлт, аялал жуулчлал хумигдсан үед жижиг, дунд үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг тогтвортой хадгалахад чухал үүрэг гүйцэтгэв.

Вьетнамын дотоодын бизнесүүд импортын, тэр дундаа Хятадын түүхий эдээс өндөр хамааралтай. Энэ нь цар тахлын үед ЖДҮ-чдийн үйл ажиллагаа саатах томоохон шалтгаан болж байв. Энэхүү хүндрэлийг давахын тулд Вьетнамын Засгийн газар аж үйлдвэр, технологи болон нэхмэлийн салбарыг дэмжих бодлогыг эрчимжүүлэв. Тухайлбал, Ханой зэрэг мужийн захиргаанаас хөрөнгө оруулалтыг татах чиглэлд газрын түрээсийн хугацааг сунгах, хөнгөлөлттэй зээл олгох зэрэг арга хэмжээнүүд хэрэгжүүлжээ. Засгийн газрын нээлттэй, зохион байгуулалттай, уялдаатай бодлого, үйл ажиллагааны үр дүнд Вьетнам улс 2020 онд эдийн засгийн өсөлт эерэг байсан цөөхөн орны нэг болов.

## **Казакстан**

Казакстан улсын жижиг, дунд болон бичил бизнесийн салбар нь нийт ДНБ-ийн 29.5%-ийг, нийт экспортын 18%-ийг нийт ажиллах хүчний 38%-ийг бүрдүүлдэг ба нийт ЖДҮ-үүдийн 25% нь хоёр хотод төвлөрсөн байдаг аж (KPMG, 2020).

Казакстан улс нь Ковид-19 цар тахлын үед хөл хорионы дэглэмийг хоёр ч удаа хэрэгжүүлж, бизнесийн үйл ажиллагаа тасалдаж, ЖДҮ-үүд ихээхэн хохирол амсжээ. Тухайлбал, KPMG-ийн мэдээлсний дагуу, 300 мянга гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа түр зогсоож, 1,6 сая гаруй хүн цалингүй ажлаас чөлөөлөгдөж, ойролцоогоор 14-15 мянган ЖДҮ-үүд зээлийн хугацаа хойшлуулах хүсэлт гаргажээ. Улмаар тус улсын засгийн газраас ЖДҮ-ийг дэмжих олон төрлийн бодлого, дэмжлэгийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлжээ. Тухайлбал:

- **Зээлийн санхүүжилт:**
  - ЖДҮ-ийн хөрөнгийг нэмэгдүүлэх 600 тэрбум тенгеийн хөнгөлөлттэй зээл
  - Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн төслүүдэд зориулсан зээл
  - Батлан даалтын сан болон хүүгийн татаас
  - Зээлийн хүүгийн болон үндсэн төлөлтийн төлбөрийн түр чөлөөлөлт
- **Салбарт чиглэсэн санхүүжилт, тусламж:**
  - Боловсруулах аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх
  - Агро-аж ахуйн цогцолборт зориулсан засгийн газрын хөгжлийн хөтөлбөр
  - Форвард гэрээгээр санхүүжүүлэх хөтөлбөрүүд
  - Бондын хүүгийн санхүүжилт
- **Татварын хөнгөлөлт:**
  - Шатахууны экспортын гаалийн татвар, онцгой албан татварыг тэглэх
  - Үл хөдлөх, газар, орлогын албан татварын төлбөрөөс хөнгөлөх
  - ХАОАТ, НӨАТ, ААНОАТ-ын төлбөрийн хугацааг хойшлуулах
  - Хүнсний бүтээгдэхүүний НӨАТ-ыг 12%-аас 8% болгож бууруулсан

- **Бусад:**

- Ур чадвартай хөдөлмөрийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, масс бизнес эрхлэлтийг дэмжих Засгийн газрын хөтөлбөр
- Ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
- Шатахууны үнийг хөнгөлөх
- Ажилгүйдлийн нөхөн төлбөр
- Түрээсийн төлбөрийн хугацааг хойшлуулах

Харамсалтай нь Засгийн газраас хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүртээмж хангалтгүй байсныг Earnst&Young компанийн судалгаанд дурджээ (EY, 2020). Тухайлбал, тус компаниас эрхлэн явуулсан судалгаанд оролцсон ах ахуйн нэгжүүдийн 15% нь Засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдэд хамрагдаж чадаагүйгээ дурджээ. Учир нь Засгийн газраас тогтоосон үйл ажиллагааны ангилалд тус байгууллагууд багтаагүй байжээ. Түүнчлэн, судалгаанд оролцогсдын талаас илүү нь Засгийн газрын дэмжлэгийг авахад ямар нэгэн хүндрэлтэй тулгарсан гэжээ. Зарим хүндрэлүүдийг дурдвал, мэдээлэл авч чадаагүй, хэтэрхий хүнд сурталтай, арга хэмжээнд хамрагдахад хэт их бичиг баримт бүрдүүлж маш олон шатлал дамжихаар байсан, дэмжлэг үзүүлж буй төрийн албан хаагчидтай харилцахад хүндрэлтэй байсан гэх мэт байв.

(KPMG, 2020)-ийн судалгаанд оролцсон нийт компаниудын талаас илүү нь Засгийн газрын дэмжлэгт хамрагдахад 3 долоо хоног ба түүнээс хугацаа шаардаж байгааг дурджээ. Түүнчлэн, судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүд хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн шаардлага, хүсэлт өгөх арга тодорхой бус, эргэлзээтэй байсныг онцолсон байна. Түүнчлэн, нэг арга хэмжээнд хамрагдахын тулд олон газар, олон төрлийн бичиг баримт бүрдүүлэн өгч, төрийн байгууллагууд хоорондын үйл ажиллагаа нийцгүйгээс дэмжлэг авч чадаагүй тохиолдлууд ч цөөнгүй байжээ. Цаашилбал, нэг арга хэмжээний Орос болон Казак хэл дээрх тайлбар ялгаатай байгаагаас аль чиглэлийг дагахаа мэдэхгүй, эргэлзээтэй байх үе ч гарсныг дурджээ. Мөн судалгаанд оролцогчдын 34% нь ЖДҮ-г дэмжих хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд оновчтой бус, ач холбогдолгүй, хугацаа болон зардал ихээр шаардсан, үр ашиггүй байсан гэж үзжээ. Судалгаанд оролцогсдын дурдсан бас нэгэн том хүндрэл нь Засгийн газрын хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар нэг хэл дээр мэдээлэх нэгдсэн нэг мэдээллийн суваг байхгүй байжээ.

Цаашилбал, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр ашиг хангалттай бус байсныг дээрх хоёр судалгаанд дурджээ. Тухайлбал, (KPMG, 2020)-ийн дагуу, судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн ердөө 11% нь “татварын түр чөлөөлөлт”-ийн арга хэмжээ нь тухайн компанийн санхүүгийн байдлыг тогтворжуулах үр дүнтэй байсан гэжээ. Цаашилбал, Засгийн газраас хэрэгжүүлсэн нийт арга хэмжээний үр дүнтэй байдлыг 10 онооноос үнэлэхэд 5.6 гэсэн үнэлгээг судалгаанд оролцогсод өгчээ.

Казакстан улсын жишээнээс харахад бусад улсын жишгээр Ковид-19-ийн үед ЖДҮ-ийг дэмжих олон арга хэмжээ авч хэрэгжүүлсэн ч мэдээлэл түгээх нэгдсэн платформ, суваг байхгүй, хөтөлбөрүүдийн шалгуур тодорхой бус, хэрэгжүүлж буй Засгийн газрын институт хоорондын харилцан уялдаа байхгүй, төвөгтэй олон шатлалтай шалгуур, хүнд суртал зэрэг хүчин зүйлсийн улмаас үр дүн багатай байжээ.

### 3. Сургамж, дүгнэлт

Ковид-19-ийн үед дэлхийн улс орнуудад бичил, жижиг дунд бизнесийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогууд ерөнхийдөө хоорондоо төстэй бөгөөд дараах төрлийн үндсэн арга хэмжээнүүдийг авч байжээ. Үүнд:

- ЖДҮ-ийн хөрвөх чадварыг дэмжих буюу татвар, нийгмийн даатгалын хөнгөлөлт, чөлөөлөлт
- Банкны зээлийн төлөлтийг хойшлуулах
- Хөнгөлөлттэй зээл олгох, санхүүгийн хүртээмж нэмэх, батлан даалтын санг өргөжүүлэх
- Дулаан, цахилгаан, түрээсийн төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх
- Ажил эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг хадгалах, татаас олгох
- Үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, төрөөс хэрэгжүүлж буй дэмжлэгт хамруулахын тулд бүртгэж албан бусаас албан секторт шилжихийг дэмжих
- Эрүүл мэндийн тоног төхөөрөмж, материалын үйлдвэрлэлийг дэмжих, дижитал шилжилтийг дэмжих, ЖДҮ-ийн онлайн борлуулалт, хүргэлтийг идэвхжүүлэх

Манай улсын хувьд цар тахлын үед дээрх чиглэлүүдээр бодлогын цуврал олон арга хэмжээ хэрэгжүүлсэн. Гэхдээ эдгээр бодлого хэр үр дүнтэй байх нь тухайн ажлын зохион байгуулалт, нарийвчилсан дүрэм журам, шаардлагатай урьдач нөхцөлүүд бүрэлдсэн эсэх гэх мэт олон хүчин зүйлээс хамаарна.

Цар тахлын үед ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, туршлага, үр дүн, олон улсын байгууллагуудаас боловсруулсан зөвлөмжөөс дараах гол сургамжуудыг авч болохоор байна. Үүнд:

1. **Мэдээллийн хүртээмж.** Цар тахал буюу гамшгийн үед иргэд, аж ахуйн нэгжүүдийг цаг үеийн нөхцөл байдал болон үзүүлж буй тусламж дэмжлэгийн талаар ойлгомжтой, цэгцтэй мэдээллээр хангах асуудал маш чухал байдаг ажээ. Үймж сандрах, буруу ташаа ойлголт түгэх, мэдээгүйгээс шалтгаалан тусламж дэмжлэг авч чадалгүй үлдэх нь цар тахлын үеийн менежментийг улам хүндрүүлдэг, үр дүнг бууруулдаг тул мэдээллийг шуурхай нээлттэй, бүх хүнд хүртээмжтэй хүргэх, гаргасан шийдвэрүүдийг ойлгомжтой эмх цэгцтэй танилцуулах нь чухал юм. Энэ тухайд улс орнууд ЖДҮҮ эрхлэгчдэд зориулсан нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлж цахим хуудас ажиллуулах гэх мэт арга хэмжээг нийтлэг хэрэгжүүлжээ.
2. **Үүрэг хариуцлагыг тодорхой болгох.** Засгийн газрын бүх нэгжүүдийн үүрэг хариуцлагыг тодорхой болгох, давхардал, зөрчил, хийдэл гаргахгүйгээр хоорондын үйл ажиллагааг уялдуулах нь чухал. Гамшгийн үед ямар үйл ажиллагааг хэн хариуцах, хэн ямар шийдвэр гаргах нь бүх хүнд маш тодорхой, ойлгомжтой байх шаардлагатай.
3. **Зорилтот бүлгүүдийг зөв, цаг алдалгүй тодорхойлох.** Гамшгийн үед төсвийн хязгаарлагдмал нөөцийг үр дүнтэй зарцуулах, тусламж дэмжлэгийг хамгийн хэрэгцээтэй бүлэгт чиглүүлэх шаардлагатай. Ковидын үед худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлал, тээврийн салбарын болон гадаад худалдаа эрхэлдэг ЖДҮ-үүд хамгийн их хүндрэлтэй тулгарч байсан. Үүний тулд шуурхай мониторинг судалгаа тогтмол хийж, нөхцөл байдалд цаг тухайд нь бодитой үнэлэлт дүгнэлт өгөх шаардлага үүсдэг байна.
4. **Тусламж, дэмжлэгийг зорилтот бүлгүүдэд онцлогт нь тохируулж хэрэгжүүлэх.** Гамшиг эрсдэлд хамгийн их өртсөн, хамгийн их дэмжлэг шаардлагатай иргэд, аж ахуйн нэгжийг зөв тодорхойлохоос гадна тэдэнд хүргэх дэмжлэгийг тохирох аргаар хүргэх нь бодлогын үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлнэ.

5. **Төрийн үйлчилгээг шуурхай болгох.** Цар тахлын үед төрийн үйлчилгээний хүнд суртал, шат дамжлага, шаардлагагүй нэмэлт дарамтууд илүү тодорч байсан бөгөөд улс орнууд төрийн үйлчилгээг хөнгөвчлөх, дижитал шилжилтийг шуурхайлах алхмуудыг авч хэрэгжүүлж байв.
6. **Нөөц бүрдүүлэх, эрсдэлийн төлөвлөгөө гаргах.** Улс орнууд, аж ахуйн нэгжүүд, иргэд ямар нэг хэмжээгээр хүндрэлтэй цаг үед зориулсан нөөцийг бүрдүүлэх, эрсдэлийн үеийн төлөвлөгөөтэй байх нь чухал болохыг цар тахлын үе тодорхой харуулав. Засгийн газрын түвшинд төсвийн алдагдал, улсын өрийг бууруулах, хуримтлалын сан бүрдүүлэх, чухал бараа түүхий эдийн нөөц бүрдүүлэх нь чухал бол иргэд, аж ахуйн нэгжийн түвшинд ч мөн хөрвөх чадварын нөөцтэй, эрсдэлийн нөөц төлөвлөгөөтэй, эрсдэлд бэлтгэлтэй байх нь чухал.
7. **Хүндрэл бэрхшээлийг боломж болгож хувиргах.** Жишээлбэл, цар тахлын үед харилцаа холбоо, интернетэд суурилсан үйлчилгээний салбарт үйл ажиллагаагаа өргөжүүлж, хүрээгээ тэлэх таатай боломж үүссэн. Өмнө удаан явцтай байсан төрийн үйлчилгээ, банк санхүү, боловсролын салбар, онлайн хурал уулзалт гэх мэт дижитал шилжилт маш хурдтай хийгдэх болсон. Гэхдээ энэ шилжилт ЖДҮ эрхлэгчдэд хүндрэл ихтэй байгаа тул тэдэнд зориулсан тусламж хэрэгтэй.
8. **Цар тахлын дараах ЖДҮ эрхлэгчдийн талаар явуулах бодлого боловсруулах.** Цар тахлын дараах ЖДҮ-үүдийн өсөлт, улмаар үндэсний бүтээмжийг нэмэгдүүлэх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого зайлшгүй хэрэгтэй. Учир нь удаан үргэлжилсэн хүндрэлтэй цаг үед аж ахуйн нэгжүүд нөөцөө шавхсан, үйл ажиллагаагаа сэргээхэд хүндрэл ихтэй байна. Ийм нөхцөлд тэдэнд зориулсан цогц арга хэмжээг боловсруулах шаардлагатай болдог. Энэ нь ЖДҮ эрхлэгчдийн зардлыг бууруулах, эрэлтийг нэмэгдүүлэх бүх боломжуудыг эрэлхийлнэ гэсэн үг юм.
9. **Бизнесийн хөгжлийн үйлчилгээ, ур чадвар дээшлүүлэх сургалт орох.** Удаан хугацаагаар үйл ажиллагаа нь тасалдсан аж ахуйн нэгжүүдэд ажилчдын ур чадварыг сэргээх, дижиталжсан, халдвараас сэргийлэх шинэ орчинд дасан зохицож ажиллах ур чадварыг олгох, зах зээл ба борлуулалтаа сэргээх чиглэлээр техникийн туслалцаа, чадавхжуулах үйл ажиллагаа, зөвлөгөө, сургалт нэн шаардлагатай болж байна. Мөн урьд өмнө хэрэгжүүлж байсан бизнес эрхлэлтийн дэмжих инкубатор, хурдасгуурын дэмжлэгээ үргэлжлүүлэх.
10. **Санхүүжилтээр хангах.** Цар тахлын дараах сэргэлтэд аль болох олон эх үүсвэрээс олон төрлийн санхүүжилт шаардлагатай болж байна. Зарим улс орон ЖДҮ-үүдэд зориулсан дижитал санхүүгийн үйлчилгээг хөгжүүлэх (мобайл санхүү, ЖДҮ хоорондын зээллэг, хувьцааны краудфандинг (equity crowdfunding) платформ гэх мэт хэлбэрүүдийг туршиж байна.
11. **Бодлого хэрэгжүүлэхдээ хувийн секторын нөөцийг илүү ашиглах.** Засгийн газар ЖДҮ-г хөгжүүлэх зорилгоо биелүүлэхэд хувийн секторын дэмжлэгийг олж авах нь чухал. Тухайлбал, ЖДҮ-үүдийн санхүү, бизнесийн удирдлагад гаднаас мэргэжилтэн ашиглах, мэргэшсэн нягтлан бодогч зэрэг зөвлөх мэргэжилтнүүдийг ЖДҮ-ийн дотоод хяналтын системийг сайжруулахад ашиглаж болно.

## Ашигласан эх сурвалж

- ADB. (2020). *Asia SME Monitor 2020*. Asian Development Bank.
- ADB. (2021). *ADB's Comprehensive Response to the COVID-19 Pandemic*. Asian Development Bank.
- ADB. (2021). *Asia SME Monitor-2021*. Asian Development Bank.
- European Bank For Reconstruction and Development. (2021). *Support for SMEs in the COVID-19 Crisis: The Case of China*.
- European Bank for Reconstruction and Development. (2020). *Support for SMEs in the COVID-19 Crisis: The Case of The Republic of Korea*. European Bank for Reconstruction and Development.
- EY. (2020). *Impact of the Coronavirus Crisis on SMEs in Kazakhstan*. EY.
- IMF. (2021). *COVID-19 Financial Assistance and Debt Service Relief Tracker*. International Monetary Fund.
- KPMG. (2020). *COVID-19 Pandemic: Are The Government Business Support Measures in Kazakhstan Effective?* KPMG.
- Nguyen, T. M. (2022). *Beyond Regime Types: Local Governance, Bureaucratic Coordination, and COVID-19 Responses in Vietnam*. KDI School.
- United Nations ECLAC. (2021). *Analysis of Policies to Support SMEs in Confronting the COVID-19 Pandemic in Latin America*. Santiago: United Nations.
- Үндэсний Статистикийн Хороо. (2022). “Аж ахуйн нэгжийн 2021 оны тооллого: Нэгдсэн үр дүн”. Улаанбаатар: Үндэсний Статистикийн Хороо.
- ЭЗСЭШХ. (2022b). *Шинэ сэргэлтийн бодлого ба хувийн секторын хүлээлт*. Улаанбаатар: Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн.
- ЭЗСЭШХ. (2022a). *Эдийн засгийг эрчимжүүлэх 10 их наядын бодлогын хувийн секторт үзүүлсэн үр нөлөө ба хэрэгжилтийн сургамж*. Улаанбаатар: Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн.